# ТҮЛШ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ ОНӨААТҮГ 2026 ОНЫ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Улаанбаатар хотын хүн ам өсч, төвлөрөл нэмэгдэж байгаагийн улмаас бохирдол нэмэгдэж, өвлийн улиралд нийслэл хотын агаарын бохирдлын 80 хувийг гэр хорооллын айл өрхийн гэрийн зуух болон аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын зуух, 10 хувийг замын хөдөлгөөнд оролцож байгаа авто тээврийн хэрэгсэл, 5-6 хувийг дулааны цахилгаан станцууд. 4 хувийг үнсэн сан, замын тоос шороо, ил задгай хаясан хог хаягдал зэрэг бусад эх үүсвэр ялгаруулж байна.

Агаар, орчны бохирдлыг бууруулах хүрээнд хийгдэж байгаа ажлууд үр дүн багатай байгаагаас хотын хүн ам, ялангуяа хүүхэд, өндөр настны дунд агаарын бохирдлоос шалтгаалсан амьсгалын замын өвчлөл улам ихэсч, эрүүл мэндэд нь ноцтой хохирол учруулж байна.

Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд 176512 угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг суурилуулж, Дэлгэцийн операторууд 24 цагаар хянаж, ППМ 100 болон түүнээс дээш заасан айл өрхүүдтэй цаг алдалгүй холбогдож урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж өгөх. шаардлагатай тохиолдолд шуурхай багийг явуулж шалтгаан нөхцөлийг нь тодруулж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллаж байна. 2026 оны 01 дүгээр сарын 01- нээс 6 дугаар сарын 23-ны хооронд хяналтын дэлгэцэд ППМ өссөн 40692 дуудлага мэдээлэл ирсний дагуу  дуудлага мэдээлэл дээр гэрээт хяналтын ажилтнууд газар дээр нь очиж урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж нийт 81384 хүний амь насыг хамгаалж ажилласан байна. Мөн 2025 оны ППМ өссөн дуудлага 6797 өрхийн 20390 хүний амь насыг эрсдэлээс хамгаалж, яаралтай тохиолдолд 374 гэрээт хяналтын ажилтан явуулж ажилласан байна.

2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 6 дугаар сарын 26-ний өдрийг хүртэлх Угаарын хийн хордлогод өртсөн 482 өрхийн 1458 тохиолдлыг байршлаар авч үзвэл Сонгинохайрхан дүүрэгт 38% /185 тохиолдол Сүхбаатар дүүрэгт 5% /26 тохиолдол, Баянзүрх дүүрэгт 23% /111 тохиолдол, Чингэлтэй дүүрэгт 16% /80 тохиолдол Баянгол дүүрэгт 3% /15 тохиолдол Налайх дүүрэгт 9% /37 тохиолдол Хан-Уул дүүрэгт 6% /28 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна. Угаарын дуудлагын тоогоороо Сонгинохайрхан дүүрэг тэргүүлж байна.

Доорх тоон үзүүлэлтүүд нь байгууллагын үйл ажиллагаа зөвхөн иргэдийн амь нас эрүүл мэндийг хамгаалаад зогсохгүй, нийгмийн аюулгүй байдал, санхүү, эдийн засгийн үр ашиг иргэдийн ухамсар, мэдлэг гэсэн олон талт үр нөлөөг бий болгож байгааг харуулж байна.

| № | Үзүүлэлт | Тоо /тайлбар | Үр нөлөө |
|---|---|---|---|
| 1 | Пийшин яндангийн үзлэг | 1.644 | Дүүрэг тус бүрээр гүйцэтгэгийг авч үзвэл:<br>• Чингэлтэй дүүрэгт 287 дуудлагад засвар үйлчилгээ үэүүлж 12 дуудлага хойшлуулсан буюу цуцлагдсан<br>• Сонгинохайрхан дүүрэгт 504 дуудлагад үйлчилгээ үзүүлж. 10 дуудлага хойшлуулсан<br>• Сүхбаатар дүүрэгт 163 дуудлагад үйлчилгээ үзүүлж. 8 дуудлага хойшлуулсан<br>• Хан-Уул дүүрэгт 107 дуудлагад үйлчилгээ үзүүлж 2 дуудлага хойшлуулсан<br>• Налайх дүүрэгт 190 дуудлагад үйлчилгээ үзүүлж 3 дуудлага хойшлуулсан<br>• Баянгол дүүрэгт 30 дуудлагад үйлчилгээ үзүүлж 1 дуудлага хойшлуулсан<br>• Баянзүрх дүүрэгг 363 дуудлагад үйлчилгээ үзүүлж 10 дуудлага хойшлуулсан байна<br><br>Нийт дуудлагын дотор Сонгинохайрхан (30.66%). Бзянзүрх (22.08%) болон Чингэлтэй дүүргүүд (17.46%) хамгийн өндөр ачаалалтай ажилласан үзүүлэлттэй байна |
| 2 | Илрүүлсэн эөрчил | 1340 | Тайлант хугацаанд нийт 1340 дуудлага хүлээн авснаас 1644 дуудлагад засвар үйлчилгээ үзүүлсэн.<br>Харин 46 дуудлага буюу 2.7 хувь нь хойшлуулсан болон цуцлагдсан байна. |
| 3 | Угаарын хий төхөөрөмж тараалт мэдрэгч | 176512 | Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд 176512 угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг суурилуулж, Дэлгэцийн операторууд 24 цагаар хянаж, ППМ 100 болон түүнээс дээш заасан айл өрхүүдтэй цаг алдалгүй холбогдож урьдчилан сэргийлэх заавар зөвлемж өгөх, шаардлагатай тохиолдолд шуурхай багийг явуулж шалтгаан нехцөлийг нь тодруулж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллаж байна. |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | ППМ өссөн дуудлага | 40.917 | 2026 оны 01 дүгээр сарын 01-нээс 6 дугаар сарын 26-ны хооронд хяналтын дэлгэцэд ППМ өссен 40917 дуудлага мэдээлэл ирсний дагуу 2509 дуудлага мэдээлэл дээр гэрээт хяналтын ажилтнууд газар дээр нь очиж урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж нийт 81384 хүний амь насыг хамгаалж ажилласан байна. |

Үр нөлөө. Угаарын хий мэдрэгч төхөөрөмжийн суурилуулалт, сургалт нь иргэдийн Эрүүл мэндийг хамгаалж, эрсдэлийг бууруулсан тул эмнэлгийн болон нийгмийн зардлыг багасгаж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж байна.

2. Нийгмийн хөгжлийн үзүүлэлт

Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд 176512 угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг суурилуулж, Дэлгэцийн операторууд 24 цагаар хянаж, ППМ 100 болон түүнээс дээш заасан айл өрхүүдтэй цаг алдалгүй холбогдож урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж өгөх, шаардлагатай тохиолдолд шуурхай багийг явуулж шалтгаан нөхцөлийг нь тодруулж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллаж байна. 2026 оны 01 дүгээр сарын 01- нээс 6 дугаар сарын 23-ны хооронд хяналтын дэлгэцэд ППМ өссөн 40917 дуудлага мэдээлэл ирсний дагуу 2509 дуудлага мэдээлэл дээр гэрээт хяналтын ажилтнууд газар дээр нь очиж урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж нийт 81384 хүний амь насыг хамгаалж ажилласан байна.